

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН  
ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 01 дүгээр  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн холбогдох зохицуулалт нь хууль хоорондын давхардал үүсгэж байгаа тул зохицуулалтыг нэгтгэх, зөвхөн иргэний өргөдөл, гомдол гаргах эрхийг баталгаажуулсан байсныг өргөжүүлж, хуулийн этгээдийн өргөдөл, гомдол гаргах эрхийг хангах, сонсох ажиллагааны мэдэгдлийг шууд хүргүүлэх боломжгүй тохиолдлыг шийдвэрлэх, захиргааны акттай холбоотой зохицуулалтын хоёрдмол утга бүхий томъёоллыг нэг мөр ойлгомжтой болгох, Ерөнхийлөгчийн баталсан захиргааны хэм хэмжээний актыг Улсын Их Хуралд хүргүүлж байх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан захиргааны хэм хэмжээний актыг хянах хугацаа, тэдгээрийг бүртгэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх зохицуулалт болон нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй, ойлгомжгүй, хоёрдмол утга бүхий бусад зохицуулалтуудыг тодорхой болгох зорилгоор дээрх хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Ерөнхийлөгчийн баталсан захиргааны хэм хэмжээний актыг Улсын Их Хуралд хүргүүлэх зохицуулалтын талаар болон Засгийн газраас гаргасан улс төрийн шийдвэрийг хэрхэн хянах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт иргэн өөрт учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх зохицуулалтын хэрэгжилтийн талаар, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хүчингүй болгож тухайн хуулиар зохицуулагдаж байсан харилцааг Захиргааны ерөнхий хуульд тусгах нь иргэний төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхийг дордуулахгүй байж чадах эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**С.БЯМБАЦОГТ**